

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН БОДЛОГО
\ХЭЭЛ ХАХУУЛЬ, ШАН ХАРАМЖЫН ЭСРЭГ

Дугаар **SD-CP2\2016**

- Бизнесийн ёс зүй ба хариуцлага бол СААДИ-н суурь үнэт зүйл бөгөөд хамтрагч нарын өмнө хүлээсэн итгэлийг дааж үйл ажиллагаагаа явуулах нь манай бизнесийн үндэс юм. Бид харилцагчиддаа шударгаар, ёс зүйтэй хандах болно гэдэгтээ итгэл төгс байна.
- Манай ажилтан бүр Саади группын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байхдаа шударга ажиллах үүрэгтэй.
- Компаний бүх ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, компаний бодлого, дүрэм журмууд, стандарт, заавруудыг баримталж ажиллах үүрэгтэй бөгөөд хуулийг мэдэхгүй байх нь түүнийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй. Тиймээс бид өөрсдийн ажилтай холбоотой хуулийг мэддэг байх ёстойгоо ухамсарладаг.
- Манай ажилтнууд аливаа дарат шахалт, хүчирхийлэл, заналхийллээс эмээлгүйгээр ажил үүргээ гүйцэтгэх эрхтэй. Бид ажилтнуудынхаа аюулгүй байдлыг нэн тэргүүнд анхаардаг. Компанийн энэхүү бодлогыг баримталж ажиллахын тулд өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг умартаж болохгүй.
- Энэхүү бодлогыг зөрчих үйлдэл хийхийг шаардсан эсхүл айлган сүрдүүлсэн аливаа тохиолдлыг шууд удирдлагадаа нэн даруй мэдэгднэ.

НЭГ. АВЛИГА

- 1.1. Саади группын хэмжээнд төрийн албан хаагч, ханган нийлүүлэгч болон үйлчлүүлэгчидтэй харьцахдаа бид хээл хахууль, шан харамж өгөх болон авахгүй байх, мөн дээрх үйлдлийг бидний нэрийн өмнөөс бусад этгээд хэрэгжүүлэхийг хатуу хориглоно. Өөрөөр хэлбэл Саади-ийн ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч хээл хахууль, авилгын үйлдэл хийх, түүнд оролцохыг хориглоно.
- 1.2. Хээл хахууль ба бусад авилгын төлбөр нь хууль бус юм.
- 1.3. Авлига нь хүлээлгэсэн эрх мэдлээ урвуулан ашиглах замаар хувийн, эсхүл компанид ашин хонжоо олох зорилготой аливаа үйлдэл гэж тодорхойлогдсон болно.
- 1.4. Авлига нь хахууль, ашиг сонирхлын зөрчил, хулгай, сүрдүүлэг, завших, залилан, компанийн хөрөнгийг урвуулан ашиглах зэрэг янз бүрийн нөхцөл байдлыг хамаарна.
- 1.5. Хахуулийг шууд, эсхүл зуучлагчаар дамжуулан хувь хүн болон хуулийн этгээдэд бизнесийн буюу төрийн ажил үүргээ зөрчиж ямар нэг үйлдэл гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байх тохиолдолд түүнд нөлөөлөхийн тулд зохистойгоос илүүг амлах, санал болгох буюу давуу тал бий болгох гэж тодорхойлох бөгөөд дараах үйлдлийг бид хийдэггүй.
 - ✓ Гэрээ байгуулах буюу тусгай зөвшөөрөл авахын тулд бэлэн мөнгө, эсхүл бусад хэлбэрээр төлбөр төлөх
 - ✓ Улс төрийн нам эсхүл холбогдох байгууллагад зохисгүй хандив өргөх
 - ✓ Хэн нэгэн этгээдэд нөлөөлж, тодорхой үйлдэл хийлгэх зорилгоор хэт үнэтэй бэлэг сэлт өгөх, эсхүл зугаацуулж, цэнгүүлэх
- 1.6. Энэ бодлогын хүрээнд хахууль нь бэлэн мөнгөнөөс гадна материаллаг үнэ цэнэ бүхий аливаа эд зүйлс болон дараах хэлбэртэй байхыг ойлгох бөгөөд бид үйлдэхгүй.
 - ✓ Хэт их үнэ бүхий бэлэг сэлт өгөх, зугаацуулан цэнгүүлэх
 - ✓ Далд санаа агуулсан хандив, өглөг
 - ✓ Бизнесийн хэрэгцээ шаардлага байхгүй байхад үйлчлүүлэгч, эсхүл албан тушаалтны аяллын зардал, зочид буудлын төлбөрийг төлөх

- ✓ Бизнесийн үйл ажиллагаа эсхүл зөвшөөрөгдсөн хүмүүнлэгийн зорилготой хамааралгүй үйл ажиллагаанд компаний өмч хөрөнгийг ашиглах
- 1.7. Бид зуучлагч, эсхүл бусад гуравдагч этгээдээр дамжуулан гэрээ байгуулах, бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зөвшөөрөл олж авах буюу бусад онцгой эрх эдлэх, давуу байдал бий болгох зорилгоор мөнгө, эсхүл аливаа материаллаг үнэ цэнэ бүхий эд зүйл (үүнд бизнес болон санхүүгийн нууц мэдээлэл, оюуны өмч багтана) санал болгох, амлах, өгөхгүй байхаас гадна аливаа бизнесийн болон төрийн байгууллагатай тогтоосон харилцаанд зохисгүй байдлаар нөлөөлөхийг хориглоно.
- 1.8. Манай ажилтнууд, итгэмжлэгдсэн этгээд, гэрээт гүйцэтгэгч эсхүл бизнесийн түншүүд ийм төрлийн үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрөхгүй.

ХОЁР. БЭЛЭГ СЭЛТ ӨГӨХ, ДАЙЛЖ ЦАЙЛАХ, ЗУГААЦУУЛАН ЦЭНГҮҮЛЭХ

- 2.1. Зохих түвшний бэлэг, дурсгалын зүйл өгөх, зугаацуулах нь ажлын сайн харилцаагч үүсгэхэд тус дөхөмтэй байдаг тул энэ бодлого нь зохих ёсны хэмжээнд бизнесийн түнш байгууллага, бусад этгээдтэй найрсаг харилцаа тогтоох боломжийг хязгаарлахгүй.
- 2.2. Гэвч зохисгүй бэлэг, зугаа цэнгэл санал болгох, эсхүл өгөх нь Саади-ийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Бэлэг, зугаа цэнгэл санал болгох нь бодит эсхүл боломж бүхий бизнесийн арилжаа, төрийн байгууллагын зөвшөөрөл зэрэгтэй ямарваа нэг байдлаар холбоотой байж болзошгүй тохиолдолд нэн аюултай. Хэдийгээр зорилго нь авилгын шинж агуулаагүй хэдий ч хүлээн авагч, эсхүл гуравдагч этгээдийн зүгээс бэлэг, зугаа цэнгэлийг зүй бус давуу байдал олж авах оролдлого хэмээн ойлгосноор эрсдэл үүсэх магадлалтай.
- 2.3. Дараах төрлийн бэлэг сэлт, зугаа цэнгэлийг огт хүлээн зөвшөөрөхгүй болно. Үүнд:
- ✓ Гэрээ байгуулсан, зөвшөөрөл олгосон, өөр ашиг хонжооны хариуд өгсөн буюу санал болгосон
 - ✓ Бизнесийн үйл ажиллагаа явуулах зорилгоор зүй бус давуу байдал олж авахын тулд санал болгосон
 - ✓ Авилгалын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн
 - ✓ Ханган нийлүүлэгч, бизнесийн түншээс манай ямарваа нэг ажилтанд санал болгосон
 - ✓ Олон нийтэд ил болсноор бидний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх магадлал бүхий
- 2.4. Бид ханган нийлүүлэгч нартай ажиллахдаа бэлэг буюу шан харамжийн нөлөөнд авталгүй бодит байдалд тулгуурлан шийдвэр гаргах үүрэгтэй.
- 2.5. Бид ажилтнууддаа дараах шинжтэй шан харамж, бараа бүтээгдэхүүн, мөнгө, үйлчилгээ зэргээр бэлэг, зугаа цэнгэл гуйх, хүсэх болон хүлээн авахыг хориглодог. Үүнд:
- ✓ Тухайн хүн ямар нэг үүрэгтэй болсон мэт сэтгэгдэл төрүүлэх
 - ✓ Тэдний бизнесийн шийдвэрт нөлөөлөх, эсхүл нөлөөлж магадгүй хэмээн ойлгогдох
 - ✓ Ажилтны хувийн ашиг сонирхол болон Саади группын ашиг сонирхлын хооронд зөрчилдөөн үүсгэж эсхүл үүсгэхүйц мэт санагдах

ГУРАВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

- 3.1. Бидний хувийн ажил хэрэг, ашиг сонирхол нь Саади компанид хүлээх үүрэг, хариуцлагатай зөрчилдөхөөс зайлсхийх үүрэгтэй.
- 3.2. Ажилтнууд болон тэдний ойр дотны хүмүүсийг нь хамарсан бодит, эсхүл магадлал бүхий ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ёстой бөгөөд хэрэв дээрх байдал үүсч болзошгүй тохиолдолд шууд удирдлагад мэдээлэх ёстой.
- 3.3. Аливаа ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлэхийн тулд хамтран ажиллагсад, харилцагчид, бусад хүмүүсээс бэлэг сэлт, зээл, төлбөр мөнгө, эдгээртэй адилтгах бусад санал ирсэн бол нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

ДӨРӨВ. ЗУУЧЛАЛЫН ТӨЛБӨР

- 4.1. Бид зуучлалын төлбөр төлөхийг хориглодог.
- 4.2. Бид аливаа зөвшөөрөл гэх мэт төрийн үйлчилгээг хүртэхдээ хууль, дүрэм журманд заасан шаардлагын дагуу холбогдох бүхий л материалуудаа бүрдүүлэн хуулийн дагуу төрийн үйлчилгээ авах эрхээ эдлэх бөгөөд энэ эрхээ эдлэхийн тулд бусдад төлбөр төлөхгүй.

ТАВ. КОМПАНИЙН ӨМЧ ХӨРӨНГИЙГ АШИГЛАХ

- 5.1. Манай ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч, гэрээт гүйцэтгэгч болон бизнесийн түншүүд зэрэг нь бизнесийн үйл ажиллагаагаа явуулах явцад зуучлагч эсхүл бусад гуравдагч этгээдээр дамжуулан давуу байдал, онцгой эрх, тусгай зөвшөөрөл олж авах, гэрээ байгуулах буюу бусад зорилгоор төрийн байгууллага, албан хаагчид, иргэний нийгмийн байгууллагуудад мөнгө, эсхүл аливаа үнэ цэнэ бүхий эд зүйл санал болгох, амлах, өгөхийг хатуу хориглохоос гадна аливаа бизнесийн болон төрийн байгууллагатай тогтоосон харилцаанд зохисгүй байдлаар нөлөөлөхийг хүлээн зөвшөөрөхгүй.
- 5.2. Байр талбай, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг компаний өмч хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглаж буй тухайн этгээдийн хувьд эдгээр нь үнэ цэнэ бүхий зүйл байна. Бизнесийн ямар нэг бодит зорилго байхгүй, олон нийтэд тодорхой ашиг тус өгөхгүй тохиолдолд үйлчлүүлэгч, төрийн албан хаагч, эсхүл гуравдагч этгээдэд компаний өмч хөрөнгийг ашиглуулахгүй.

ЗУРГАА. УЛС ТӨРИЙН ХАНДИВ

- 6.1. Бид ямар ч нөхцөл байдалд аливаа улс төрч, улс төрийн нам эсхүл холбогдох байгууллага, улс төрийн намын албан тушаалтан болон нэр дэвшигчид шууд эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан хандив өгөхийг хориглоно.

ДОЛОО. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАРТАЙ ХАРИЛЦАХ, ЛОББИДОХ

- 7.1. Төрийн албан хаагч гэдэгт төрийн байгууллагын \ям, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэх мэт\ албан тушаалтан, ажилтан, тэдгээрийн үр хүүхэд болон төрөл саданг хамтад нь ойлгоно.
- 7.2. Аливаа төрийн албан хаагч мөн эсэх талаар эргэлзэж байгаа бол та компаний хуулийн асуудал хариуцсан нэгжид хандана.
- 7.3. Бид үйл ажиллагаагаа явуулахдаа шударга, бүтээлч байдлаар хамтран ажиллахыг эрмэлздэг бөгөөд бидний үйл ажиллагаатай ямар нэгэн байдлаар холбогдож буй төрийн болон бусад аливаа байгууллага, хүмүүстэй өргөн хүрээнд зөвлөлдөж ил тод, хариуцлагатай хаьцдаг.
- 7.4. Манай ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч бизнесийн үйл ажиллагаа явуулах явцад зуучлагч, эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан давуу байдал, онцгой эрх, тусгай зөвшөөрөл олж авах, гэрээ байгуулах буюу бусад зорилгоор төрийн байгууллага, албан хаагч, бизнесийн, иргэний нийгмийн байгууллагуудад мөнгө эсхүл аливаа үнэ цэнэ бүхий эд зүйл санал болгох, амлах, өгөхийг хатуу хориглохоос гадна аливаа бизнесийн болон төрийн байгууллагатай тогтоосон харилцаанд зохисгүй байдлаар нөлөөлөхийг хүлээн зөвшөөрөхгүй.

НАЙМ. ХҮМҮҮНЛЭГИЙН ХАНДИВ, ТУСЛАМЖ, НИЙГЭМ БОЛОН ОРОН НУТАГТ ХИЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 8.1. Бидний үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурал, өвчинтэй тэмцэх, байгаль орчныг хамгаалах, иргэд эсхүл байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилгоор хүмүүнлэгийн хандив, тусламж үзүүлдэг.
- 8.2. Гэвч ийм төрлийн хандив, тусламж нь тодорхой нэг төрийн албан хаагч, улс төрч эсхүл намд ач тусаа өгөхөөс сэргийлж, гуравдагч этгээд үүнийг зүй бусаар зарцуулахгүй байх тал дээр хяналт тавин ажиллана.
- 8.3. Хэрэв хандив, тусламж нь ёс зүйгүй байдал үүсгэх, эсхүл үүсгэх нөхцөл бүрдүүлэх шинжтэй бол хандив тусламж үзүүлэхгүй, хөрөнгө оруулахгүй байвал зохино.

ЕС. ИВЭЭН ТЭТГЭЛЭГ

- 9.1. Гэрээ, зөвшөөрөл эсхүл тодорхой зохицуулалтаар давуу тал олж авах төлөөсөнд ивээн тэтгэлэг амлаж, санал болгож болохгүй. Бизнесийн үйл ажиллагаа явуулахад зүй бус давуу байдал олж авахын тулд эсхүл бидний зорилго ташаа ойлгогдох магадлалтай бол ивээн тэтгэхгүй байвал зохино.

АРАВ. БУСАД

- 10.1. Энэхүү бодлогыг Саади группын бүх ажилтан дагаж мөрдөнө.
- 10.2. Зөрчсөн тохиолдолд Ажилтанд хариуцлага тооцох журмын дагуу арга хэмжээ авна.
- 10.3. Батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
- 10.4. Хэрэв аливаа үйлдэл энэхүү бодлого эсвэл холбогдох хуульд нийцэх эсэх талаар танд асуух зүйл байвал хуулийн нэгжид хандана уу.

